


ТӨСЛИЙН ЗОРИЛГО БОЛОН ҮР ДҮН

ТӨСЛИЙН ЗОРИЛГО: ХОЛБОГДОХ БАЙГЛЛАГУУДЫН (MCSD, CDC, GASI) БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ ВАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ТӨРИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, СУРГАЛТ, ТАЛБАЙН ЗААВАРЧИЛГАА, ХЯНАЛТЫН ЧАДАВХИ ДЭЭШЛЭХ.



- (4) Хамтран ажиллах хугацаа
2017 оны 6 сараас 2021 оны 6 сар (48 сар)
- (5) Хамтран хэрэгжүүлэх байгууллага
БХБН-ны Барилгын Материал, Үйлдвэрлэлийн Бодлогын Хэрэгжилт Зохицуулалтын Газар, МХЕГ-ын Хөдөлмөр Нийгмийн Халамжийн Хяналтын Газар, Барилгын Хөгжлийн Төв ТӨҮГ-ын сургалтын хэлтэс
- (6) Төслийн бүрэлдэхүүн

- 1) Япон талаас
- ✓ Мэргэжилтэн
Урт хугацаагаар: Ахлах зөвлөх (Барилгын салбарын ХАБ-ын зөвлөх) болон Төслийн зохицуулагч
Богино хугацаагаар: Барилгын хөдөлмөр хамгааллын хяналт, Барилгын хөдөлмөр хамгааллын сургалт (чиглэл тус бүрээр хэдэн хүн)
 - ✓ Японд сургалт зохион байгуулах
 - ✓ Тоног төхөөрөмж (Төслийн ажлын хэрэгцээнд ашиглах тоног төхөөрөмж, бусад хэрэгцээт зүйлс)
 - ✓ Бусад зардал (төслийн ажлын үр дүнг дээшлүүлэхэд шаардагдах зардлууд)

2) Монгол талаас

- ✓ Хамтран ажиллах ажилтныг томилох
Төслийн захирал (Барилга, Хот Байгуулалтын Намны Төрийн Нарийн Бичгийн дарга)
Төслийн менежер (Барилга, Хот Байгуулалтын Намны Барилгын Материал, Үйлдвэрлэлийн Бодлогын Хэрэгжилт Зохицуулалтын Газрын дарга, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын Хөдөлмөр Нийгмийн Халамжийн Хяналтын Газрын дарга, Барилгын Хөгжлийн Төв ТӨҮГ-ын орлогч дарга)
- ✓ Байр, тоног төхөөрөмж (БХБН болон БХТ дээрх оффис)
- ✓ Төслийн ажилтай холбогдолтой бусад зардлууд (Төслийн оффисийн үрсгал зардал г.м)



Төслийн оффисийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Самбуугийн гудамж,
Глобал бизнес төв, 601 тоот
Утас/Факс: 7000-3486
<https://www.jica.go.jp/mongolia/english/>

1. Төсөл хэрэгжих Улс / Төслийн нэр
 - (1) Төсөл хэрэгжих улс: Монгол Улс
 - (2) Төслийн нэр: Японоор: 建設分野における労働安全管理能力強化プロジェクト
Англиар: Project on Strengthening the Capacity for Occupational Safety Management in the Construction Sector
2. Төслийн хүсэлтийн талаар
 - (1) Одоогийн байдал ба тулгарч буй асуудал
Монгол Улсад (цаашид "Монгол" гэх) 1990 оноос зах зээлийн эдийн засгийн системд шилжсэнээр эдийн засгийн хурдтай өсөлтийг дагаж хот байгуулалт, тохижилтын ажил хөгжсөөр байна. Хөгжил дэвшилтэй холбоотойгоор барилгын салбарт ажиллагсдын тоо нэмэгдсэнээр барилгын ажил явагдаж буй талбай дахь үйлвэрлэлийн осол гарсаар байна.




ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР



"БАРИЛГЫН САЛБАРЫН ХАБ-ЫН ХЯНАЛТЫН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ"

2010-2014 онд зөвхөн Улаанбаатар хотод барилгын талбайд 268 осол гарч (үүнээс нас баралт 54%, хөдөлмөрийн чадвараа алдсан 32%), хохирогсдын ихэнх нь 18-35 насны залуучууд байна. Ослын шалтгаан өндрөөс унах болон нуралтаас үүссэн осол 54,6%, өргөх буулгах механизмийн осол 12,5%, техник, тоног төхөөрөмжийн осол 10,7% байна.

УЛААНБААТАР ХОТОД ГАРСАН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛЫН ТОЙМ 2015 ОН




Энэ байдлыг шийдвэрлэхийн тулд Барилга, Хот Байгуулалтын Нам болон Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газраас барилгын үйлдвэрлэлийн ослоос сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Захиалагч болон барилгын компаниуд ХАБ-н талаарх ойлголтыг дээшлүүлж, тогтолцооны хувьд ХАБЭА-тай холбогдолтой хуулиуд, барилгын аюулгүй байдлын зааварчилгаа зэргийн чиг үүргийг хангалттай хэмжээнд биелүүлэх нөхцлийг бүрдүүлэхээр ажиллаж байна. Мөн, барилгын аюулгүй байдал хариуцсан захиргааны ажилтнууд болон барилгын талбайн даамлуудад ослоос сэргийлэх мэдлэг олгох сургалтууд явуулж байна.

Дээрх байдлаас барилгын үйлдвэрлэлийн ослыг тэглэхийн тулд, холбогдох хууль тогтоомжийн боловсруулалт болон ослоос сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлэх, захиргааны байгууллага, хөдөлмөрийн хяналтын байгууллага болон барилгын компанийн ХАБЭА хариуцсан ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх шаардлагатай.

УЛААНБААТАР ХОТОД ГАРСАН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛЫН ТОЙМ 2015 ОН

БОЛОВСРОЛЫН БАЙДАЛ




(2) Арга хэмжээ

Монголын ХАБЭА холбогдолтой хууль нь ажилчдыг хамгаалах зорилготой "Хөдөлмөрийн хууль" (1999 он), "Улсын хяналт шалгалтын тухай хууль" (2003 он), "ХАБЭА хууль" (2008 он), хуулиуд батлагдсан бөгөөд 2015 онд ХАБЭА-н хуулийн нэг хэсгийг (ХАБ-ыг дээшлүүлэх зэрэг) өөрчлөн засварлахын зэрэгцээ "Барилгын ажлын ХАБЭА-н дүрэм"-ийг боловсруулж байгаа. Барилгын стандартад зориулсан "Барилгын хууль"-д 2008 он, 2015 онд ХАБЭА-тай холбоотой хэсгийг (захиалагчийн үүргийг дээшлүүлэх тухай) өөрчлөн сайжруулсан.


Мөн үйлдвэрлэлийн осол, ажлаас шалтгаалсан өвчлөлийг бууруулах, "ХАБЭА-н холбогдох орчныг сайжруулахын тулд 4 дэх удаагийн үндэсний хөтөлбөр (2012-2016 он) боловсруулж, хэрэгжүүлэн барилгын үйлдвэрлэлийн ослоос сэргийлэх арга хэмжээний хүрээнд зорилт тодорхойлж, холбогдох байгууллагуудын чадавхийг дээшлүүлэхийг зорьж байна.

"Барилгын ажлын ХАБЭА-н дүрэм" нь одоогоор Хууль зүйн яамнаас баталгаажуулагдаж байгаа, жишээ болгож ашиглав.

ОСОЛДСОН ХҮМҮҮСИЙН ХҮЙС



ОСОЛДСОН ХҮМҮҮСИЙН НАС



Эх сурвалж: Улаанбаатар хот, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар

УЛААНБААТАР ХОТОД 2015 ОНД БҮРТГЭГДСЭН ОСОЛ /САЛБАР ТҮС БҮРЭЭР/

БҮРТГЭГДСЭН ОСОЛ САЛБАРААР	Ослын зэрэг		
	Хөнгөн гэмтсэн	Хүнд гэмтсэн	Нас барсан
	82 /42,5%/	90 /46.6%/	21 /10.9%/
Эрчим хүч	2	2	1
Уул уурхай	3	1	0
Хөдөө аж ахуй	0	0	1
Барилга	7	18	10
Хүнс	15	6	0
Зам тээвэр, харилцаа холбоо	14	18	3
Худалдаа, Үйлчилгээ	5	4	0
Боловсрол	7	8	1
Эрүүл мэнд	4	9	0
Төрийн байгууллага	11	11	2
Бусад	14	13	3

Эх сурвалж: Улаанбаатар хот, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар

3. Төслийн танилцуулга

- Зорилго
Уг төсөл нь барилгын үйлдвэрлэлийн ослыг бууруулахын тулд авах арга хэмжээг боловсруулах (Барилгын үйлдвэрлэлийн ослоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх), зааварчилгаа, жишээ судалгааны эмхэтгэл боловсруулж бэлдэх, захиргааны байгууллага, хөдөлмөрийн хяналтын ажилтан болон барилгын компаниудын ХАБЭА хариуцагчдын сургалтын систем бүрдүүлэх болон сургалт явуулах, загвар талбай дахь холбогдох байгууллагуудын (БХБН, МХЕГ, БХТ) хяналтын чадавхийг дээшлүүлэх зорилготой.
- Төсөл хэрэгжих талбай / хамрах хүрээ
Төсөл хэрэгжих газар: Монгол улсын нийт нутаг дэвсгэр
Загвар талбай: Улаанбаатар хот дотор ажил явагдаж буй барилгын загвар талбай (төсөл эхэлсний дараа сонгох)
- Төслийн өгөөжийг хүртэгчид (зорилтот хэсэг)
 - Шууд өгөөж хүртэгч
Холбогдох байгууллагуудын захиргааны ажилтнууд, хөдөлмөрийн хяналтын ажилтан болон барилгын компанийн ХАБЭА хариуцсан ажилтнууд
 - Эцсийн өгөөж хүртэгч
Барилгын компанийн ажилчид